

МОНГОЛ ХЭЛ БИЧИГ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ**11-Р АНГИ**

А хувилбар

2024 онысарын

Хугацаа: 60 минут

Нийт оноо: 35 оноо

Суралцагчийн нэр:.....

Анги..... бүлэг

Санамж: Эхийг анхааралтай уншижойлгоод даалгаврыг гүйцэтгээрэй.

Цэнхэр өнгийн үзгэн балаар гаргацтай цэвэр бичнэ.

"Олон болоорой"

Би яг одоо муу жаатгар эгчийгээ бодож сууна. Улаа бутарсан хацартай, жартайсан онигор нүдтэй эгчийгээ би "Жаатгар" гэж дуудаад уурлуулдаг байлаа. Бид хоёр ердөө нэг насны зөрүүтэй ч миний эгч надаас биеэр том, товируун охин байжээ. За, дээрэлхүү гэж учиргүй. Тоглосон ч, уурласан ч тэр намайг ганцхан хумьж дороо хийгээд, уурласан бол гэвшинө, тоглосон бол гижигдэнэ. Эг самбаагүй гижигдүүлэх гэвшүүлснээсээ дор шүү дээ. Цагаан сарынхаа хэдэн чихрийг хэрчинээндээ нуувч эгч аль цагийн хамаг л том чихрийг нь түүж идчихээд жартайтал инээж зогсдог сон. Миний зэвүү, дургүй хоёр зэрэг хүрвч надаас толгой өндөр түүнийг яаж ч сарвалзаад дийлдэггүй байлаа.

Хөдөөний хүүхдүүд дөрөв тавтайгаасаа л хурга ялгаж, үнээ ивэлгэхээс эхлүүлээд малын захад зогсож, эцэг эхийнхээ гар хөлийн үзүүрт дэм болох гэж хичээцгээдэг сэн. Түүндээ ч дуртай. Би найм, эгч ес хүрдэг жилийн хаврын амралт юм даг. Аав сум яваад эзгүй байлаа. Өглөөгүүр ая намдуухан байсан тэнгэр үд дундаас эхлэн бүрзийж, цасан шуурга нүүр нүдгүй балбаж эхэллээ. Ээж яаран сандран гарахад эгч бид хоёр ч зүгээр суугаад үлдсэнгүй. Ээждээ дэм болох гэж хонины захаар гүйлдлээ. Ээж "гэртээ ор, ор" гээд байгаа бололтой хоёр гараа савчаад байна. Эгч бид хоёр бараа, бараандаашуу бөртгөнөн гүйцгээв.

Нэг мэдсэн хонь хоёр тасраад нэг хэсгийг нь эгч бид хоёр дагаад гүйж явна. Эгч ч бүснийхээ үзүүрээр намайг уяад Эгчийгээ дагаад гүйгээд байгаарай гэж билээ. Энэ хооронд хонь ч нэлээн холдсон хэрэг. Богино хөлийн мал ч гэлээ уруудсан л бол бидэн шиг амьтдад гүйцэгдэнэ гэж үгүй. Хаврын шуурга гэдэг нэг балбахаараа аархуу ч гэж жигтэйхэн. Сөрсөн нэгнийг сөхрүүлж байж л санаа амрах аятай. Туниа муутай зарим төлөг борлон энд тэндгүй л бөмбийлдөөд унаж байсан санагддаг юм. Миний нүүр ам тэсэхийн аргагүй чимчигнэж, амьсгаа авахад ч бэрхтэй болж хайрдаж хөлдсөн цас руу өөрийн эрхгүй шургачин уналаа.

Би сумын эмнэлэгт ухаан орсон юм. Хацар ам, гар хөл хайрагдсанаас биш бусдаар бол гайгүй. Эмнэлгээс гарч гэртээ иртэл

хоймрын авдар дээр эгчийн зураг зулын гэрэлд сүүмэлзэж байсан юм даа. Ингээд л би эгчгүй болов. Эгчийгээ би үгүйлдэг байлаа. Үгүйлэлгүй ч яахав дээ. Ихэр юм шиг тэрсхэн, инээх уйлах нь ч зэрэг шахуу, үй зайгүй хоёр юм чинь. Хэдийгээр би чихрээ нуух хэрэггүй болсон ч нууж идээгүй чихэр амтгүй болчихдог юм билээ. Эгчдээ би чихрээсээ өгдөг байсан. Эгчийнхээ зургийн өмнө чихэр тавихыг харсан ээж маань аргаа үүрээд гэлдэрчихдэгсэн.

Өдөр хоног ээлжилсээр хэн хүний амнаас сэм унах “Азтай хүү” гэх үгсийн дундуур би хүний ганц хүү болон өслөө. Эцэг эх минь ганц хүүдээ гарч татсангүй, хатуу үгч хэлсэнгүй. Цэргийн насанд ирэхэд би арваад жилийн өмнөх атигар жаахан хүү биш болсон байв. “Банзарын ганц хүү баймгүй сайхан залуу болж. Аргагүй ээ, хорвоод үлдье гэж үлдсэн хүү дээ” гэх яриа салхины үзүүрт тэгнэгдсээр чихний омог ирвэгнүүлэхэд цөс хөөрсөн амьтан цэрэгт мордож билээ. Одооны цэрэг яахав дээ, хаврын тугал бяруу болоогүй байхад л хал цэрэг болчихдог хачин богинохон алба юм хойно тэгсгээд л халагдсан.

Тэр жилийн зуны дэлгэрийг хэлэх үү. Ёстой л нэг газар багадаж, дэлхий давчидсан, ай мөн “бачим” зунсан. Ааг, омог хоёртойгоо ам булаалдсан агсам залуу нас намайг нөмрөөд авах нь тэр. Нутаг нугын эмс охидын харцыг, эрчүүдийн сэтгэлийн хороор даруулж явсан үедээ мэлмэрээ хархан нүдэт Дэлгэрмаатайгаа таарсан даа. Тэгээгүй бол миний хазаарыг хэзээ, хэн, хэрхэн хантайрахыг одоо төсөөлөхөд бэрх.

Дэлгэрмаа надад гурван охин төрүүлж өгсөн ч миний сэтгэлд “Удамзалгах хүүгүй” гэх туниа муутай, түнирхлын цог үе үехэн уугьжасан тэрхэн мөчид багын анд олгой Чимэдийн □ Чи биш эгч чинь үлдсэн бол Банзарын хэдэн адууг эргүүлэх хүү төрүүлэх байсан даа □ гэх солгой үг намайг архи хэмээх шингэн хүлгийн хондлойд зайдан мордуулж орхив. Зуны гурван сарыг гудайтал айраг архи эргүүлдсээр унаа морио улдааж, унаган биеэ эцээсэн амьтан гэрийнхээ уяанд дөрөө мулталлаа.

Аавын бор морь уяан дээр эргэцнэ. “Хөгшин ирж дээ” гэх бодолтой давхцан дотор эрээлжилж морин тэрэг түшин огьж гарлаа. Тэгтэл ууц нуруун дундуур тас буугаад явчихлаа. Яав ийв гэх зуургүй дахиад нэг буув. Ухасхийсэн бол бариад авах байсан биз. Гэхдээ би тэгсэнгүй. Хамрын дор эрээлжлэх аавын гутлын ээтэн хоншоорыг ширтсээр ахиад нэг гөвүүлэв.

“Эгч чинь чамайг ингэж хүний сүг болж яв гэж чиний төлөө амиа өгөөгүй байх шүү. Наад бөндгөрөө усанд үйчхээгүй бол бодоорой муу шаар минь” гэж хэлчхээд эргэж харсангүй мордох нь тэр. Бор морины хөнгөн алхаа товор товор гишгэлсээр холдов. Ташуурын гувруу нуруу хорсгохоос илүүтэй хэлсэн үг нь тархи манаргаж орхив. “Чиний төлөө амиа өгөөгүй” гэдэг үгийг хэлэхдээ аавын хоолой тэгтлээ хяхт насны учир юу билээ?

Энэ үгийг бодож би гэрийн хаяанд гурав хоног хэвтлээ. Гурван охин маань над руу ирмээр авч гэрэвшээд байгаа бололтой. Дэлгэрмаа хонь хурга, үхэр тугал, сааль сүү, хүүхэд шуухад гэсээр дээлээ тайлах завгүй ажээ. Тэр их ачааг ганцаар үүрэх Дэлгэрмаа юундтай манатай. Гэхдээ тунарсан мэлмэрээ харц нь тамирдуу л болохоос гундчихаагүй хараг дана.

Гол руу гүйх гурван охиныхоо араас ширтэнгээ □ Аав эртээр юу гэгчхэв дээ □ гэж ихэд энгүүнээр асуух аялвал □ Үг хэлэхтэй болсныг бодоход чи өнөө маргаашгүй тэнэх байлгүй. Тэгэхээрээ эхээсээ очиж асуухгүй юу □ гээд хурдхан холдох минь гэсэн шиг охидынхоо араас

дэгдчихлээ. Үе үе хэн нүүрээ шудрахыг бодоход уйлжл яваагаас зөрөхгүй. “Тиймээ, ээжл учрыг хэлэх юм байна” гэж бодовч уулзана гэхээр халуун. Их үдийн халуун өнгөрөөгөөд мордсон би оройн саалиар үхрийн зэлэн дээр бөртгөнөх ээжийн дэргэд хулгаж, хулгаж очлоо.

“Ишш, ингэж ч явах гэж дээ чи” гэсэн урам хугарсан харцаар ширтэж суусан ээж □Амьд явахад учир бий хүү минь□ гэсээр яриагаа эхэлсэн дээ. □Тэр ёрын шуурга жаахан уясаж, нүд орохтой зэрэг л бид хотлоороо эрэлд гарч таван саахалтын дайтаас та хоёрыг олсон. Нэг бөвийсөн цул юм. . □гээд ээж нүдэндээ дүрслэв үү гэлтэй таг чиг болсноо шүлсээ гүдхийтэл залгиж уртаар санаа алдаад □Эгч чинь дээлээ тайлж чамайг тумлайдаж ороогоод, өөрөө бас давхар тэвэрсэн байсан. Ээ бас их тэвчээр шүү. Чиний хамраас халуун уург гарч байсан даа. Аав чинь та хоёрыг давхраар нь тэврээд гэртээ авчирсан. Тас тэврээд хөшчихсөн эгчийг чинь салгах гэж эцэг чинь л элгээ эмтэлж, цээжээ урсан юм шүү □гээд ээж цааш нь ярьж чадсангүй. Ярьсан байлаа ч би сонсож дөнгөхөөргүй болсон байв.

“Есхөн настай, тэр бээлийнхэн чинээ амьтны хуруухан чинээ зүрх эцсийн цохилго хүртлээ зөвхөн миний л төлөө байж шүү дээ” гэж бодохоор хаанаас ч юм өгсөх халуун зураа өр исгэн огшиж, эхэр татуулан гадагшлав. Нэг мэдэхэд ээж ч алга, үхэр тугал, ер нь бүгд алга. Тугалын зэлэн дээр хусрангийн бяруу шиг дүнхийтэл хэр удаан сууснаа анзаараагүй ээ.

Тэндээс би □Амь тавихад ч бас учиртай юм байна □гэж шивнээд боссон доо. Энэ цагаас хойш гашуун ус хоолойгоороо давуулаагүй. Одоо манайх зургаан охинтой. Дэлгэрмаагийн минь мэлмэрээ хархан харц харзны ус шиг сэргэсэн шүү. Тогоон чинээ гэдэстэй тэр минь хүүхэд шиг л хөнгөмсүү.

Охид маань намайг ноолох дуртай. Аавынхаа хэвтэж суухыг андахгүй. Хэзээний л ирээд шавчихна. Би ч гэсэндээ хотны ат шиг ноолуулж хэвтэх дуртай. Сэтгэл минь аль тэртээх амьдралын харгүйд үлдсэн долоон настай хүү мэт, харин эгч минь бүр зургаагийн зургаан “Жаатгар” болоод ирчихсэн намайг ноолж буй мэт санагддаг даа.

Одоо төрөх хүүхэд минь охин уу, хүү юү хамаагүй ээ. Тэр хаврын шуурганд эгч минь намайг тэвэрч хэвтэхдээ □Олон болоорой миний дүү□ гэж шивнэсэн ч юм билүү хэн мэдлээ дээ. . .

Асуулт даалгавар:

Дараах асуултад хариулж бичээрэй.

1. Салхи шуурга маш хүчтэй байсан гэдгийг амьдчилан дүрсэлсэн үг хэллэг 2-ыг олж бичээрэй. (2 оноо)

.....
.....

2. “. . хэн хүний амнаас сэм унах “Азтай хүү”. . .”, “Аргагүй ээ, хорвоод үлдье гэж үлдсэн хүү дээ” гэх яриа салхины үзүүрт тэгнэгдсээр. . .” гэсэн хэсгүүдийн онцолсон үгийг зохиогч ямар зорилгоор ашигласан бэ? /2 оноо /

.....
.....

-
-
3. Аавын хоолой тэгтлээ хяхтнасны учрыг 2 шалтгаанаар баталж бичээрэй. /2 оноо /

-
-
-
4. “бээлийнхэн чинээ амьтны хуруухан чинээ зүрх” гэсэн хэсэгт ямар дүрслэх хэрэглүүр байгааг олоод яагаад гэдгийг тайлбарлаж бичээрэй. /2 оноо /

Дүрслэх хэрэглүүр:.....

Тайлбар:.....

5. **Өглөөгүүр ая намдуухан байсан тэнгэр үд дундаас эхлэн бүрзийж, цасан шуурга нүүр нүдгүй балбаж эхэллээ.-** гэсэн өгүүлбэрийг гишүүдээр зурж, хэв маягийг тодорхойлоорой. /2 оноо
-
-

6. Найрч угсарсан нийлмэл үгийг сонгоно уу. /1оноо/

- A. Алтан нар
- B. Нохойн дуу
- C. Салхины аяс
- D. Аянга цахилгаан

7. “шан-на –чих-аарай” гэсэн бүтээврийн нийлцийг зөв бичсэн нь аль вэ? /1 оноо/

- A. шагначхаарай
- B. шагначихаарай
- C. шанначихаарай
- D. шаганчихаарай

8. Нутгийн аялгууны үгийг халх аялгуунд зөв буулгасан нь аль вэ? /1 оноо/

Түрэн тоонтоттай хаанаб?

- A. Төрсөн тоонтотнай хаана вэ?
- B. Түрхэн тоонот хаана вэ?
- C. Төрсөн нутаг хаана вэ?
- D. Тоонот хаанав?

9. “Хэдэн залуус морь тарлаж, нутгийн өвгөд уяа сойлгыг шинжинэ” өгүүлбэрийн онцолсон бүтээврийг солин найруулахад аль нь тохирох вэ? /1 оноо /

- A. –х
- B. -вч
- C. -магц
- D. -н

1. ХОЁРДУГААР ХЭСЭГ: БИЧИХ ЧАДВАРЫГ СОРЬСОН ДААЛГАВАР / 10 оноо /

“Олон болоорой” өгүүллэгийн талаар уншигчийн захидал бичээрэй. (Үгийн тоо 180-200)

Бичихдээ захидлын бүтцийг эргэн санахаас гадна дараах агуулгын бүтцийг ашиглаарай.

Эхлэл хэсэг: Зохиогч болон өгүүллэгийн талаар товч танилцуулах

Гол хэсэг:

- Өгүүллэгийн талаарх мэдрэмж, сэтгэгдлээ баримт нотолгоотой бичих
- Зохиолоос хамгийн сонирхолтой, анхаарал татсан зүйл нь юу байсан, яагаад гэдгийг дүгнэж бичих
- Уншсан эхийнхээ гол санаа, дэвшүүлсэн асуудлын талаар дүгнэж бичихдээ зохиолчийн үзэл бодлын талаар дүгнэх
- Монгол ахуй, ёс зан заншил, уламжлал хэрхэн туссаныг дүгнэж бичих

Төгсгөл хэсэг:

- Өгүүллэгийн хамгийн үнэтэй санаа нь юу байв? Яагаад?
- Хүмүүст өгүүллэгийг унших сонирхол төрүүлэхүйцээр бичих гэх мэт.

БАТЛАВ

СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

Б.ТӨМӨРЧӨДӨР

МОНГОЛ ХЭЛ БИЧИГ ХИЧЭЭЛИЙН АНГ И ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

11-Р АНГИ

Б хувилбар

2024 онысарын.....

Хугацаа: 60 минут

Нийт оноо: 35 оноо

Суралцагчийн нэр:.....

Анги..... бүлэг

Санамж: Эхийг анхааралтай уншижойлгоод даалгаврыг гүйцэтгээрэй.

Цэнхэр өнгийн үзгэн балаар гаргацтай цэвэр бичнэ.

Харьд очсон монгол морьд

Харь холын газар замын эрхээр очсон хүлэг морьд унаган нутаг, ижил дасал болсон сүрэгтээ очих гэжтүмэн бэрхшээлийг туулан хатируулахын тухай өгүүлэхэд үг эвлэхгүй мэт...

Монгол эр хүн, морь хоёрын амин холбоо, эх нутгаа гэх чин сэтгэлийн тухай домог түүх, ном судар олон байдаг л даа. “Адгуус гэдэг хүнээс ялгаагүй сэтгэл зүрхтэй амьтан...” гэж буурлууд учирладаг сан

Тэртээ арван гуравдугаар зууны үед Монгол морьдын туурайн хээгээр дэлхийн талыг тамгалж байсан түүх бий. Тэр үед хэчнээн олон хүлэг унаган нутгаасаа холдож, хагацал тэмцэл амсаж байсан бол. Эртний түүх гэлтгүй, энүүхэн ойрын баримтуудыг л харахад үнэндээ элэг эмтэрч өр өмөрмөөр. Нутаг ус руугаа амь дүйн тэмцэж, олон мянган өртөө газрыг туулахын энэлэн зовлонг мэдэрнэ гэдэг юутай хэцүү. Бид өргөнтал, өндөр даваа, гаталшгүй гүнзгий мөрөн голуудыг ч туулаад ирсэн морьдын тухай домог болгон ам дамжуулж ярьдаг. Тэр байтугай Вьетнамын арлаас гүйсэн ганц морь Шар мөрөн, Алашаны их элсэн цөлийг туулаад ирсэн тухай ч үзсэн харсан мэтээр ярих хүн эдүгээ бидний дунд ч бий. Монгол морийг унаж эдэлж байсан гадаадын хүмүүсийн яриа, тэмдэглэл дурсамж зэрэг түүхэн баримтуудаас үзэхэд энэ бүхэн худал зүйл огт биш бололтой. Цэнхэр гаргийг доргиулсан галт дайны талбарт ялалт байгуулаад шархтайгаа ирсэн морьдын тухай зүрх зүссэн баримтууд ч олон байх юм. Энэ бүхнийг эргэцүүлэн бодоход Монгол хүн морин эрдэнээ төрийн сүлдэндээ залж, түүндээ залбирахын учиг багадах мэт...

Нас бие гүйцсэн хойноо хүний нутагт очсон морь байтугай, эхийнхээ хээлэнд байхдаа харь газар очиж, хүний нутгийн хөрсөн дээр тэнцсэн унага, уугуул нутаг ус руугаа гүйжирнэ гэдэг юу гэсэн үг билээ. Монгол эх орондоо, аймаг хошуу дамжуулж зарсан хүлэг морь ижил сүрэг, нутаг ус руугаа гүйдгийг мэдэхгүй хүн бараг байхгүй л дээ. Тухайлбал: Наран ургах зүг одоогийн Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутгаас Ховд аймгийн Зэрэг суманд худалдагдаж очсон хурдан хүлэг хэдхэн хоногийн дараа ижил сүрэгтээ сувдарсан тунгалаг хөлс дуслуулан гүйж очсон

гэдэг. Энэ мэтээр тоочвол хүлэг морьдын нутгаадаа гүйсэн тухай хууч яриа маш олон бий. Гэхдээ харь гадаадын улс оронд танихгүй мэдэхгүй, олон уул даваа, гаталшгүй туулшгүй олон гол мөрнийг туулаад нутагтаа ирнэ гэдэг үүнтэй адил зүйл бишээ. Хэт алсаас гүйж Монгол эх нутгийнхаа ариун салхины сэжүүрийг амтлаад хилийн зурвас давжамжилгүй үрэгдсэн морьдын тухай ярих үүнээс өөр л дөө.

Дэлхийн хоёрдугаар дайн гэж Европ тивийг дарийн утаа нөмөрсөн ёроолгүй зовлонг Монгол морьд мөн л амссан. Орос зөвлөлтийн ахан дүүсдээ туслахаар Улаан армийн хэрэгцээнд шилдэг 485 мянган агт морь цуглуулж, 33 мянган морийг зөвхөн дайны талбар луу илгээжээ. Гэвч энэ морьдын хэд нь Монгол нутаг руугаа гүйсэн бол, хэд нь Герман цэргийн суманд өртсөн бол гэж бодохоос зүрх хайлмаар. . . Оросын армид агт морьдыг хүргэж өгөхөөр төлөөлөл болж олон малчид очсон байдаг. Тэд дайны тухай ярихаасаа илүүтэй “Манай морьд Днепр мөрнөөс үс уугаад гарахдаа ихэнх нь нүдэндээ нулимстай, бүгд л нутгийнхаа зүг сэрийтэл харцгааж байсан. . .” гэж самсаа шархируулан ярьж буй дүрс бичлэг бий.

Монгол адуу гэдэг ийм л эх оронч ийм л тэнгэрлэг мал гэдгийг бид умартах ёсгүй. Хаана дайн болно тэнд Монгол морь л түүчээлж, хаанахын улс ялалт байгуулна тэнд Монгол морь л шагшигдаж байсныг бид өнгөрсөн түүхээс ийнхүү харж байна.

“Дайны морь” гэж саяхан дэлхийн кино урлагийн сор бүтээл дэлгэцнээ гарч, олон улсад шуугиан тарьсан. Угтаа тухайн кинон дээрх анжис чирсэн морь бол дайны морь биш, ертөнцийн дөрвөн зүг найман зовхисыг олон зуун жил хураажирсэн Монгол морьд л байж.

Нүүдэлч түмний их баяр цэнгэл наадмын цэцгэн ширмэлтэй зурхайг алтан туурайгаараа гижигдэн уралддаг Монгол морьд зөвхөн наадмынх байгаагүйг бид мартах учиргүй ээ. Ө.Цогт-Эрдэнэ

Асуулт даалгавар:

1. Дээрх эхээс монгол морины хамгийн сэтгэл хөдөлгөм үйл явдлыг бичнэ үү. /2 оноо /

.....

.....

.....

2. Дараах үгсийн утгыг тайлбарлан бичнэ үү. /2 оноо /

-салхины сэжүүрийг амтлаад

.....

.

-анжис чирэх

.....

3. Монголчууд морио молор эрдэнэ хэмээн нэрлэдгийн учир юу вэ? /2 оноо /

.....
.....
4. Монгол морьдын эх нутаг руугаа гүйдэг шалтгааныг 3 баримтаар нотлон бичээрэй./ 2 оноо /
.....
.....
.....

5. “Тэр үед хэчнээн олон хүлэг унаган нутгаасаа холдож, хагацал тэмцэл амсаж байсан бол.-гэсэн өгүүлбэрийг гишүүдээр зурж, хэв маягийг тодорхойлоорой./2 оноо /

6. Найрч угсарсан нийлмэл үгийг сонгоно уу./1оноо/

- A. Алтан нар
- B. Нохойн дуу
- C. Салхины аяс
- D. Аянга цахилгаан

7. “шан-на —чих-аарай” гэсэн бүтээврийн нийлцийг зөв бичсэн нь аль вэ? /1 оноо/

- A. шагначхаарай
- B. шагначихаарай
- C. шанначихаарай
- D. шаганчихаарай

8. Нутгийн аялгууны үгийг халх аялгуунд зөв буулгасан нь аль вэ? / 1 оноо/

Түрэн тэн тоонтоттай хаанаб?

A.Төрсөн тоонтотнай хаана

B.Түрхэн тоонот хаана вэ?

C.Төрсөн нутаг хаана вэ?

D.Тоонот хаанав?

9.”Тариаланчид буудайгаа хурааж, малчид өвөлжөө рүүгээ нүүцгээнэ” гэсэн өгүүлбэрийн онцолсон бүтээврийг солин найруулахад аль нь тохирох вэ?

A.-вч

B. -н

C. -магц

D. -тал

10. Залгавар залгахад “ь” нь “и” болохгүй үгийг олно уу./1 оноо /

A. Сахь-ж

B. барь-жээ

C. соль-могц

D. холь-оо

11. “өдрийн од шиг” гэсэн хэлцийн ойролцоо утгатайг нь сонгоорой. /1 оноо /

A. Ус цас шиг
нэг

B. нуур далай шиг

C. нүдний гэм

D. газраар

12. А.П.Чехов “Хамелеон” өгүүллэгийн дараах хэсгээс дотоод орчныг тодорхойлно уу./1 оноо /

“Очиж үзвэл, пингийн үүдний дэргэд өнөөх хүн баруун гараа дээш өргөж, цустай хуруугаа олонд үзүүлэн байв. Түүний хагас согтуу царайд хорсол илэрхий. ...Очумелов түүнийг ажиглавал алтны дархан Хрюкин мөн аж. Тэдний дунд будилаан гаргасан цагаан гөлгөн нохой

бүх бие нь дагжин чичирч, цогнойн сууна. Түүний нулимст нүдэнд айсан шинжилэрхий.

- A. Харамсал, харуусал, дүүрэн орчин
- B. Уур хилэн хийгээд айдас хүйдэс бүхий орчин
- C. Уур хилэн хийгээд уйтгар гуниг бүхий орчин
- D. Түгшүүр шаналгаатай орчин

13. О.Бальзак “Эцэг Горио” туужид эцэг Горио ямар орчинд амь тавьсан бэ? Зохиолын гадаад орчныг гүйцээгээрэй. “Түшиг болж байгаа хүн.....байсан” /1 оноо /

- A. Оюутнууд буюу Бьяншон, Растиньяк байсан
- B. Охид нь буюу Анастизи, Дельфина байсан
- C. Байшингийн эзэн Воке байсан
- D. Байшингийн үйлчлэгч Сильвия байсан


14. Төрөл бус утгат үгийг олоорой. /1 оноо /

- A. Гараг
- B. Гарц
- C. гарам
- D. гараа

15. “Гагнасан гинжийг таслагтун” өгүүлбэрийн онцолсон үгийн язгуурыг олоорой. /1 оноо /

- A. гагна
- B. ган
- C. гаг
- D. гагнуур

16. Үндэсний бичгээс кирилл бичигт хөрвүүлээрэй. /5 оноо /



1. ХОЁРДУГААР ХЭСЭГ : БИЧИХ ЧАДВАРЫГ СОРЬСОН ДААЛГАВАР / 10 оноо /

Дээрх “Харьд очсон Монгол морьд” эхэд монгол морины ухаалаг, хийморьлог амьтан болох тухай өгүүлжээ. Эхийн найруулгын арга хэлбэрийг ашиглан “Морио дээдлэх монгол ухаан” сэдвээр 180-200 үгэнд багтаан эх зохион бичээрэй.

Бичихдээ : Дараах агуулгын бүтцийг ашиглаж болох юм.

Эхлэл хэсэгт : Монгол морьдын бахархам үйл явдлуудуудаас бичих

Гол хэсэгт : Монголчуудын морио хэрхэн дээдэлдэг тухай баримтад үндэслэн бичих

Төгсгөл хэсэгт : Морьдоо хайрлаж , өсгөн үржүүлэх талаар өөрийн бодлыг бичиж төгсгөх